

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ҮЕД “АЖ БАЙДЛЫН СЭДЭВТ ЗУРАГ” ХӨГЖСӨН НЬ

Ц.Эрдэнэцог, Sc.D, профессор, ДУТС

Abstract: To develop topic of livelihood painting in empire of Bogd khan I brief story

Since 1910, Mongolian people had understood their national conscious, then to started movement of freedom heavily. Painter who painted God, haven't been painting only iconography. They started to paint realism and its affected development of Mongolian fine arts. Then fine arts included topic of social and popular paintings and to de-veloped topic of livelihood paintings.

In 1911, Mongolian people established independent country and divided to Manj China. Since that time, Paint-ings which show social life and actions of Bogd khan s castle around, are several and serial paintings. B.Sharav painted “One day of Mongolia”, “To be born kids” (1911). The painting shows more than ten labour of mainly live-stock breeders during autumn including migration, offer-ing of sacrifice on an Ovoo, moving of hay, making of felt, hunting, etc. “To be born kids ” painting shows the life of fairly well-to-do Mongolian household during summer, when there is an abundance of milk and other livestock produce.

In Mongolian people s mind, idea of sin and bene-faction which is action of their feeling, tongue and body, can be their destiny. It's descriptive over paintings. But artists didn't paint implication of to develop change of the order.

Specific of these paintings which include symbolism, benefaction, good luck and charity, affected to Mongolian traditional symbol and culture. Then the paintings are “re-alist' Mongolian paintings.

New arts and streams are appeared by Mongolian livelihood. It's originated automatically. VIII Bogd khan engaged topic of the livelihood paintings and contributed to some progressive.

Livelihood paintings which exaggerate real life, was considered abstract things. Then the paintings could be specific realist painig, because it s combined abstract and real.

Some artists who painted God, started to descriptive several different, common life. That's affected to Mongo-lian people' mind of independent and their social order. So that creations aren't “criticism realism

But populations painted paintings of playing carts which show to deride to aristocracy, misters and salesmen. The paintings couldn't be famous, because they were devel-oped only family by family.

In topic of paintings can be to reflected painters' m ind and in some ways to expression social of the idea.

Therefore in Bogd khan's period, to develop topic of the livelihood paintings and the paintings could be affect to herdsmen' mind and could be new step of development of Mongolian paintings.

1910-аад оноос Монголын ард түмний үндэсний ухамсар сэргэж, эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөж эхэлжээ.

Энэ үеэс бурханч зураачид гурван зууны туршид дангаар зонхилж ирсэн бурхан шашны сэдвээс халин гарч, жинхэнэ бодит амьдралыг зурж эхэлсэн нь дүрслэх урлагт гарсан шинэ дэвшил байлаа. Эдгээр зураачийн бүтээлд байгаль ертөнц болон нийгмийн байдал, хүний бий болгосон “ахуйн орчин” тусгалаа олсон байдаг. Ингэж монгол зурагт хүн нийгмийн харилцан үйлчлэл, хүнийг хүрээлж буй байгалийн орчин ба ахуйн орчин гүнзгий тусгалаа олж өрнө дахины нийгмийн амьдралын сэдэвт зургаас ялгарах өвөрмөц онцлогийг бүрдүүлж чадсан байна.

Тэр цаг үед нэрд гарсан Б.Шарав "Марзан", Г.Дорж, Сономцэрэн, Жүгдэр, Лодой лам зэрэг

энэ зураачид Монголын үндэсний зургийн урлагт бодит үнэн байдалд шүтэн дулдуйдсан шинэ арга барил, шашны бус сэдвийг нэвтрүүлж" /Б.Н.М.А.У-ын Түүх. 1968, 594/ аж амьдралын сэдэвт зургийг үүсгэн хөгжүүлэгчид болохыг монголын түүхийн зохиолуудад онцлон тэмдэглэсэн байдаг.

Тэр үед ард түмний дунд гараар зурж бүтээсэн хөзөр, үйчүүрийн зураг нэлээд дэлгэрсэн байв “Ийм төрлийн зурагт мөн монголчуудын шүтлэг бишрэлийн санаа, байгаль нийгмийн үзэгдэл юмс, түүний цаад мөн чанар, дотоод хэлхээ холбооны тухай ойлголт төсөөлөл туссан байдаг онцлогтой” болохыг судлаач тэмдэглэдэг (Баяртөр, 2009, 12). Энэ төрлийн зурагт ноёд, хатад тэдний зарц албат, шивэгчин нарын дунд болж буй зөрчил, лам хуврага хийгээд сүсэгтэн ардын явдлыг өгүүлсэн үйл явдалтай зургууд түгсэн ба мөн “Алтан

богдын шил” зэрэг монгол ардын уртын дуунууд, “Сумьяа гүн”, “Сүнжидмаа”, “Хандармаа” зэрэг ардын богино дуунаас сэдэвлэсэн зурагт дуу бүрийн утга санааг дүрслэн зурсан нь угтаа аж амьдралын сэдэвт зургийн нэг үүтгэл болно.

Дурдан буй үед Цагаан Жамбын “Жаргалын найман морь”, “Эвт дөрвөн амьтан”, “Тэмээн сүрэг” зэрэг мал, амьтныг байгалийн байдалтай уялдуулж үзүүлсэн “Амьтны сэдэвт” бүтээл гарчээ. Ерөөсөө монголчууд нь таван хошуу малаа бэлгэдэн дээдэлж дүрслэн зурж, сийлж бүтээгээд өнгө ялгаж тодруулаад гэрийн хойморт залж, амьдшуулан тахиж ирсэн эртний уламжлалтай ард түмэн юм. Эдгээр хөзөр, үйчүүр, тахилга шүтээн, ардын дууны агуулгаас сэдэвлэсэн зургууд нь айл айлд бүтээгдсэн үндсэндээ ахуйн хэрэглээний шинжийг агуулсан жижиг зургууд болно.

Харин нийгмийн амьдрал, аж байдлын сэдэвт уран бүтээл дан XX зууны эхэн үеэс төрөлжин хөгжиж эхэлжээ. Аж амьдралыг харуулсан зургууд нь эхэндээ хүрээ, хийдийн байдлыг харуулсан зураг байсан буюу сэдэвт зураг гэхээсээ өмнө сүм хийдийн орчныг тоочин дүрсэлсэн “үзүүлэн зураг” мэт байжээ.

Жүгдэрийн зурсан “Их хүрээ”, зураач Балганы зурсан “Их хүрээний зураг”, Дамбын “Зая гэгээний хүрээ” нэр нь үл мэдэгдэх зураачийн XIX зууны дунд үеийн “Өргөө”-г дүрсэлсэн зурагт Дашчойлин хийд, Гандантэгчинлэн хийдийг төвлөрүүлэн ойр орчмын хашаа, байшин, гэр хороолол, Дамбадаржаалин, Амарбаясгалант, Манзуширийн хийд, Амгаланбаатар хот, Туул, Сэлбэ гол, хүрээний дөрвөн талын их уулсыг хамруулсан өргөн дэлгэр орон зайг багтаан зурж үзүүлэхийг чухалчилсан байдаг.


Эдгээр зурагт уулын энгэрт эсвэл тал дээр босгосон сүм, хийд нь хүрээллийн зохион байгуулалттай баригдсан байх ба зургийн төвд гол сум, дуган түүнийг тойроод хошуу, хүрээ хийдийн алба байрладаг орд, өргөөг дүрсэлж, хүрээний төвийн гадна талаар энгийн ард олны гэр хороог дэс дараалуулан зурж, хот төлөвлөлтөд ангийн давхаргын ялгаа үйлчилж байсныг үзүүлжээ.

Дараахан нь дан сүм хийдийн зураг нь хүрээ, орчмын байдлыг нийгэмд гарч байдаг онцлох үйл явдалтай уялдуулан зурж үйл өрнөлтэй сэдэвт зураг хөгжиж эхэлжээ.

Зураачдын зурсан “Хүрээ цам”, “Арван засгийн бөх”, “Сайн хааны хүрээ Майдар”, “Их хүрээний цам” зэрэг зурагт ард олон олноор цуглардаг Цам, Майдар, Даншиг наадам зэрэг томхон ёслолуудыг бүтээлийнхээ сэдэв болгон дүрсэлсэн байдаг.

XX зууны эхэнд зурсан “Долоон хошуу даншиг” зурагт их хүрээний ойролцоо Хүй мандал гэдэг газар халхын долоон хошуу наадамд цугларч, шар бөсийн хот гэж нэрлэгдэж байсан. Богдын шар асар майхныг гол дунд нь байрлуулж, түүний эргэн тойрон хаад ноёдын асар майхныг хүрээний байршлаар буулгасан байх бөгөөд эрхэс ямбатан нарын хүрээнээс гадуур энгийн ард олны хөл хөдөлгөөн өрнөж байгааг үзүүлжээ. Энэ зургийн үйл өрнөлийг дүрслэн уншвал баруун хойд талд нь төв асар голлосон наадмын талбай дээр хурдны морь гарч байх буюу түүнийг наадамчин олон сонирхож байгааг дүрсэлжээ. Хоёр талбайн хоорондуур наадамчдын асар майхан, морины уяа байх ба морьтой, явган хүмүүс холхилдож, айраг цагаа бялхсан наргиан цэнгэл эд өрнөж буй байдлыг харуулжээ.

Зураач Гэмпилийн Доржийн зурсан “Ламын гэгээний Майдар” гэдэг зурагт Майдар эргэх ёслолд цугларсан олон хөндлөн эгнээгээр үелэн цуварч, нэгэн зүг толгой хандуулсан байх ба ногоон морин толгой цухуйсан Майдарын өндөр тэрэг зүүн гараас гол шугамаар аажуухан хөдөлж, чимэг жанцан барьсан лам нар, төрөл бүрийн хөгжимчид, хүрээний гэсгүй, умзад тэргүүтэн шашны мяндагтнууд дэс зэргээр даган цуварч, тэдгээрийн араас ард олны цуваа урагшилж байдаг. Энэ зурагт цугларсан олныг дан хажуу тийш харуулан зурахдаа толгой талын, гол төвд хэргэм тушаалтнуудыг томоор тушаал багасгаж захруугаа ойртох тутам хүмүүсийн хэмжээ багасаж, цувааны хамгийн доод захад яваа уранхай дээлтэй ядуу хүнийг бүр жижгээр дүрсэлжээ.



Г.Дорж "Ламын гэгээний Майдар" XX зууны эхэн үе, зургийн хэсэг, Дүрлэх Урлагийн Музей

Зургийн ихэнх хэсгийг шар, улаанаар алгалсан лам нараар дүүргэж, тэдний хувцас хэрэглэл, нүүр царайг дүрсэлсэн байх бөгөөд хэтрэнгүй донж байдалд зохих хэмжээний шог элэглэл ажиглагдана. Эрдэмтэн Н.Цүлтэм “Дурдагдаж байгаа эдгээр зураг урлагийн хувьд онц гойдын зүйлгүй боловч энэхэн бага хугацаанд сүм дуган дотор байсан зургийн урлал нийгмийн тавцан дээр дэвшин гарч уран зургийн түүхэнд үзэгдээгүй өөрчлөлт болж, өчигдрийн бурханч нар өнөөдөр нийгмийн амьдралыг зурах гэж эрмэлзэх болсон нь аргагүй шинэ цагийн улирал орсны шинж мөн” болохыг онцлон тэмдэглэсэн байдаг (Н.Цүлтэм, 1988, х. 65).

Зураач Б.Шаравын “Богдын ногоон ордон” бүтээлд Богд хаант монгол улсын нийгмийн амьдралын байдлыг VIII Богдын орд өргөө, сүм дуганы эргэн тойрон болж байгаа үйл явдлаар зураглан үзүүлжээ. Энэ зурагт Богд хааны амьдардаг орд өргөө, сүм дуган, ордны хэрмэн хашааны дотор гадна, морь малын хашаанд болж байгаа элдэв явдлыг дүрсэлжээ. Богдын ордон нь хол ойрын сүсэгтэн хүмүүс, ард түмэн олноор цуглардаг ихээхэн хөлийн газар байсныг энэ бүтээлийн үйл өрнөл гэрчилнэ. Энэ бүтээлд Богд хааны цогцолборыг орчин тойрны байдалтай нь уялдуулж зурсан байх ба ордны эргэн тойронд

болж буй үйл өрнөлийг тоочин зурсныг үзвэл: жууз тэрэгтэй ямбатан, морьтой явган мөргөлчид, зүлэг ногоон дээр зугаацан наргиж байгаа хүмүүс, торгон цэргийн байрны орчимд цэргүүдийн хооронд болж байгаа элдэв хачирхалтай үйл явдлуудыг хүртэл илэн далангүй үзүүлжээ.

Б.Шаравын “Хайстай лаврин” зурагт хааны ордон болон эргэн тойронд байрлах захиргаа, үйлчилгээний албаны жижиг дуган хэлбэрийн байшин, том жижиг гэр, асрууд байрлах агаад туулын голд завь салаар хөвж байгаа хүмүүс, голын захаар заан, буга, жижиг морьд зэрэг богд хааны амьтны хүрээлэнд байсан ховор амьтад, ордны араар үхэр сүрэг цаашилбал, сангийн түлээ, өвс ачсан хөсөг тэрэгний цуваа, морьтой, явган хүмүүсийг зуржээ.

Эдгээр зурагт барилга, хашаа байшинг бараг нислэгийн өндрөөс харж, доторх бүх юм илхэн байгаагаар зурсан ба хоосон зай талбай ихтэй сийрэг зохиомжтой, хүн амьтны дүрсийг хэтэрхий жижигрүүлж зурсан тал ажиглагддаг бөгөөд ҮШ богд Жибзүндамба хутагтын ордны орчин тойрон дахь эмх замбараагүй байдлыг үзэшгүй марзан байдлаар зурж үзүүлсэн байдаг.

Дээрх зургуудад “Алсад байгаа гэр, хашаа, байшин, тэнд байгаа хүний дүрсийг ч хамгийн наана байгаатай адил тэнцүү хэмжээтэй дүрсэлсэн

нь нэгж талбайд аль болох их хэмжээтэй орон зайг багтааж илэрхийлдэг харааны олон цэгийн байгууламжтай монгол зургийн зохиомж, уран сайхны сэтгэлгээний онцлог” юм (Батчулуун, 2011, х.172). Энэ зурагт үйл өрнөл бүхнийг өндөр дээрээс харагдах мэт дэлгэр тавиу байдлыг илэрхийлсэн задгай зохиомжийн өвөрмөц аргаар харуулахдаа өнгийн аажим уусгалт, чөлөөтэй татлага зураасаар гаргасан нь тэр үедээ өнгө, дүрслэлийн шинэлэг хэлбэр болжээ.

Б.Шаравын Их хүрээний амьдралын сэдэвт цуврал зургуудад цайвар шаргал дэвсгэр дээр улаан хүрэн, хөх, цэнхэр бор хүрэн голдуу өнгөөр ордон, сүм, дуганы хашаа, гэрийн халз, хаалга, үүд, хүмүүсийн хувцас хэрэгсэл, амьтан малын зүсийг ялгаж, хүнд бараан татлага, зураасаар хүрээлж зуржээ. Эдгээр зурагт гэр, байшинг цэвэр цагаан бус цайруу цагаан өнгөөр уусган зурсан бол юмсыг өнгө өнгөөр цул таглаж нямбай зурааслаж гүйцээхийг урьтал болголгүй харин аль болох бийрийн уран чөлөөтэй татлагыг чухалчилж жинхэнэ эртний уламжлалт зургийн арга ажиллагааны онцлогийг илтгэжээ.

Мөн зурагт улс төрийн утга санааг агуулаагүй мөртлөө амьдралын үнэн байдлыг далд ёгт утга санаагаар гаргасан зүйл их байна. Германы эрдэмтэн Д.Хайссиг “Буддын шашны хөгжлийн 3-р үе шат” /Д.Хайссиг, 1998, 40/ буюу бурхны урлагийн бүтээлийн “оргил үе” ардын зураг төдийлөн тодроогүй байхад сүм дуганаас гарч, байгалийн орчинд чиглэсэн байгаль, орчныг амьдралтай хослуулсан зураг буй болсон нь “Аж байдлын зураг” төрөлжин хөгжихөд үндсэн суурь нь болжээ. Эрдэмтэн Н.Цүлтэм зохиолдоо: “Ямар ч гэсэн эдгээр зургууд шашны урлагийн элдэв тиг хэмжээнээс бүрэн чөлөөтэй, хүүрнэлийн зохиомж, хөнгөн будсан тодорхой дүрслэлээр болж байгаа үйл явдлыг хамгийн ойлгомжтой илэрхийлдэг ардын зургийн шинж чанарыг хадгалсан реалист зураг” болно гэж бичжээ (Цүлтэм 1988, х.65). Ингэж байгалийн байдал, хүрээний суурин амьдралыг бодитоор үзүүлдэг “Задгай орчны зураг”-ийн төрөл бий болж улмаар иргэний хөдөлмөрийн сэдэв хөгжиж эхэлжээ.

Монголын ард түмэн 1911 онд Манж хятадын ноёрхлоос салж тусгаар тогтносон хаант улсыг байгуулсан жилээс Богд хааны зарлигаар нийслэл хүрээний ойр орчинд болж байсан үйл явдал, нийгмийн амьдралыг харуулсан том жижиг нэлээд цуврал зураг зурсан байдаг. Энэ талаар зураач Д.Дамдинсүрэнгийн дурсамж зохиолд: “Их хүрээний нэрт зураач Тойсүмлин аймгийн Цэнд баруун урд хэсгийг, Сангай аймгийн Сүнгийн

Цэдэнжав зүүн урд хэсгийг тус тус төлөвлөн авч олон зураачдыг удирдан зохион байгуулж, хүрээнээс гадагш дөрвөн чиглэлээр аялж замд тааралдсан бүхнээ зурж тэмдэглэж...эх хүрээний ойр орчмыг харуулсан том зураг бүтээгээд (Богд хааны ордон музейн) ойролцоо өндөр саравчтай том самбарт нийтэд үзүүлж байсан” гэж бичжээ (Д.Дамдинсүрэн, 2003, х.81). Гэвч гамингийн их бууны суманд өртөж энэ задгай байгаль дээр зохион байгуулсан “үзэсгэлэн”-ийн зураг сүйдсэн байна. Богд хаанаас нийгмийн амьдралыг дүрслэн харуулсан бүтээлийг зурж гүйцэтгэхийг дахин зарлиг болгосноор зураач Б.Шарав Монголын нэг өдрийн амьдралын сэдэвт зургийг зурсан гэж эрдэмтэд нотолдог. Харин зураач бүтээлээ туурвихдаа мөн хүрээний нэрт зураач нөхдийн зурж цуглуулсан судалбар зургаас санаа авч зургийнхаа үйл өрнөлийг баяжуулсан байхыг үгүйсгэхгүй юм. И.И.Ломакина зохиолдоо “Богд хааны ордны зураачийн хувьд түүний бүх том хэмжээний зургуудаа зарлигаар туурвисан нь хэнд ч ойлгомжтой” гэж онцлон бичсэн байдаг (Ломакина, 1974, 142). Мөн эрдэмтэн Г.Сономцэрэн зохиолдоо: “...анх Богд хаан Б.Шарав, сийлбэрч Лувсан гэдэг хоёр хүнд өөртөө таалагдах зураг зурж, сийлбэр сийлж ирэхийг даалгасны дагуу зурсан” (Сономцэрэн нар 1989, 49) гэсэн бол, 1911-1912 оны үед Б.Шарав “Нэг өдрийн амьдрал”, “Үрс гарч байгаа нь” хэмээх хоёр бүтээлийг богдын захиалгаар зурсан болохыг эрдэмтэн судалгааны зохиолд мөн дурдсан байдаг (Баяртөр, 2008, х.62).

Б.Шаравын “Нэг өдрийн явдал” (1911) зурагт элдэв үйл явдлыг дэлгэр уудам талд эсвэл уул толгодын энгэр, хажууд болж байгаагаар үзүүлсний дотор хурим найр хийж байгаа, эсгий хийж, мал сүргээ хурааж, үрс гарч байхад буга намнаач хар гөрөөчин, мод цагаалж хөрөөдөж байгаа хүмүүс, зэргийг ойн чөлөө завсраар, уул толгодын ар өврөөс үзэгдэж байгаагаар зуржээ. Дээрх бүтээлд мөн гэрийн гадаа, гэр дотор болж байгаа үйл явдлыг ч хүртэл ил харагдаж байгаагаар зохиомжлон зуржээ. Монгол зургийн дүрслэл нь зөвхөн гадаад овор дүрслэлийн арга зарчим төдийхөн зүйл бус харин аливаа юмсын дотоод үл үзэгдэх шинжийг оновчтой дүр дүрслэлээр тодруулан хийсвэрлэж илэрхийлдэг өвөрмөц барилтай.

Энд ажиглагдаж байгаа өөр нэг онцлог гэвэл эрт цагаас монголчуудад ан ав хийж, мал аж ахуйгаа өсгөн үржүүлж, хангай, тал, говь нутгаар нүүдэллэн амьдрахдаа жин тээх, мал тууварлаж оторлох нутаг сэлгэх зэрэг газар нутгийн

хуваарилалтын уламжлалт загвар мөрдөгдөж байсныг мөн тусгаж өгчээ.

Энэ зурагт малчин ардын мал сүргээ маллах, тариа ногоо тарьж хураах, мал, амьтны түүхий эд, сүү шимийг боловсруулах эсгий хийх ажил үйлс гээд жилийн дөрвөн улиралд нар саргүй, борви бохис хийлгүй зүтгэсэн... хичээнгүй хөдөлмөрийн шимээ хүртэж амьдрах ёс, хөдөөгийн ард түмний амьдралын байдлыг тодорхой гаргахыг чухалчилжээ. Б.Шаравын бүтээлийн уран сайхны дүрүүд нь тус бүрдээ үйл өрнөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ мөн зохиомжийн ерөнхий нэг агуулгад нэгдэж байна. Тухайлбал, хуучны уламжлалт ураг холбох, бэр буулгах, хүүхнийг хүчээр богтлон (эхнэр болгон) авах ёс, түүнчлэн эсгий хийх, гүүний үрс гаргах, мал хөнгөлөх, уул, овоо тахих ёс, оршуулгын зан үйл зэргийг дүрсэлснийг ажиглахад хүн, мал амьтны содон дүр, зан ааш оршихуйн өвөрмөц онцлог нь ялгаран тодорно.

Монголын ард түмний сэтгэлгээнд “нүгэл буян

үйлийн үр хэмээх ойлголт нь хүн бүрийн бие, хэл, сэтгэлээр үйлдэх аливаа явдал мөр бүхэнд баримтлах хэв ёс суртахууны хэм хэмжээ” болно гэж профессор Ш.Чоймаагийн зохиолд өгүүлсэн байдаг (Чоймаа, 1998, х.89). Тэгвэл монгол зургийн бүтээлд ч энэ уламжлалт гүн ухааны ойлголт гүнзгий тусгалаа олж тогтсоныг энэ бүтээлийн үйл явдлын өгүүлэмж харуулж байна.

Мөн зураач Б.Шаравын “Үрс гарч байна” (1911) бүтээлд дэлгэр зуны нэг өдөр хөдөөгийн нэгэн чинээлэг айлын эргэн тойрон болж байгаа ажил үйлс, хүмүүсийн хооронд болж байдаг элдэв учрал явдлыг дүрсэлснээс тодруулбал: баяд ноёд чинээлэг, хутагт хувилгаад хагартлаа найрлан наргиж, умаахан болтлоо согтож хөлчүүрч хөглөж байхад харц ардууд тэдний гэр, орны бүхий л ажлыг үнэнчээр амжуулж, хоёр нарны хооронд борви бохисхийх чөлөөгүй зүтгэж байгаа хуучин ёсны нийгмийн үнэн байдлыг тодорхой үзүүлэн байна.



Б.Шарав "Үрс гарч байгаа нь" 1911-1912 он, зургийн хэсэг, Дүрэтэх Урлагийн Музей

Энэ бүтээлийн өгүүлэмжийн талаар доктор Л.Батчулуун бичихдээ: "Б.Шаравын сэдэвт зургууд жирийн санаа, үүдэл санаанаасаа үндэслэн шууд зохиож зурснаар зогсохгүй домогзүй, бөө мөргөл, дом шившлэг, монгол угсаатны зүйн нарийн дэг ёсыг баримталж зурсан, зарим нь яах аргагүй нууц тарнийн ёсны далд ухамсарт дүрүүд байдаг" (Батчулуун, 2009, х.130) гэж онцлоод жишээлбэл: хавь ойрын сайн уургачид цугларч, уурганыхаа үзүүрт хив, хадаг зүүн, гүүний үрс гаргах ёсыг гүйцэтгэж байгаа нь эртний монгол бөөгийн тахилга, мөргөлөөс үүдэлтэй ёс заншлын тусгал болохыг тодруулжээ (мөн тэнд). Гүүг ихэвчлэн үрс сар буюу зуны эхэн сарын бар өдөр барьж, намар нохой өдөр тавьдаг ёс бий бөгөөд гүү барьснаас гурав хоногийн дараа буюу айраг тэгш иссэн үед гүүний үрс гаргах ёслол үйлдэж, найр, наадам хийдэг ёс энэ бүтээлийн гол агуулга зургийн зохиомжийн төв нь болж байна (С.Бадрал, 1999, б).

Энэ бүтээлд идээ цагаа сав дүүрэн бялхаж, цалгисан даллагын их найрын явдлыг зонхилон үзүүлж зургийн дэвсгэртийн зүүн доод хэсэгт адуу барих, цорвуудаж ногтлох, эмнэг сургах, гүү саах, унага татах, адуу мал сүргээ тамгалах, хөнгөлөх, азарга тавих үрс гаргах зэрэг адууны зан үйлийн бүхий л арга ажиллагааг гүнзгий харуулжээ. Үхэр, хонио сааж байгаа, эсгий хийж байгаа газар болж буй явдлуудаас тодруулбал: хонь гаргаж байхад золбин нохой хонины толгой зуугаад зугтаж байгаа, ажлын хажуугаар амжуулж хосолж учрах гэсэн хүсэл сэтгэлээ илчилж байгаа залуус болоод олны харцнаас далд газар бие сэтгэлийн хүсэл юугаа амжуулан жаргаж буй хос гээд амьдралд тохиолдох элдвийн явдлуудыг ёгт хошин дүрслэлээр үзүүлжээ. Харин энэ дүрслэлүүд нь жирийн инээдэмт явдлуудын цуглуулга бус тэр цаг үеийн ард түмний амьдралын үнэн дүр зураг юм.

Б.Шарав бүтээлдээ олон үйл явдал, өргөн дэлгэр нутаг орныг хамруулан дүрсэлсэн боловч шууд нүдэнд үзэгдэж, мэдрэхүйд өгөгдөж байгаа бүхнийг бус харин гүн гүнзгий утга агуулга бүхий юмс үзэгдэл санаа бодлыг сонгон авч дүрслэн илэрхийлж юмсын уг гол шинжийг товойлгон үзүүлэхийг эрмэлзсэн байна. Ингэж хязгааргүй үргэлжлэх огторгуйн наран, саран дор сав, шим ертөнцийг хүслийн ертөнц, дүрст ба дүрсгүй ертөнц сэтгэлийн ертөнц өөрөөр хэлбэл, бие, хэл, сэтгэл байнгын зөрчилд байх учир шалтгааныг тусгасан ажээ.

Дүрслэл илэрхийллийн энэ арга үзэгдэл юмсын аль нэг талыг туйлчлан өгүүлэх төдий зүйл бус харин хүний амьдрал, байгаль ертөнц,

улс нийгмийн тухай төсөөлөл, гоо сайхны таашаал мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх шууд зохион туурвих чөлөөт боломж олгодог байна. Доктор Л.Батчулуун "Шарав нүсэр заншмал үйл явдал бүхнийг уул толгодоор тусгаарлан зохиомжилж, баатруудынхаа төрх байдлыг уран чадмаг дүрслэлээр товойлгон, дотоод сэтгэл хөдлөлийн шууд хийгээд дам холбоог ч ярвигтай онжид хэллэг, ёгт санаагаар илэрхийлж чаджээ" гэж онцолжээ (Батчулуун, 2007, х.7). Ялангуяа юмс үзэгдлийн биет, бодит чанарыг шууд оноон дүрслэхээс даамжирч, бүр далд утга санаа, таамаглал тэргүүлж зүйрлэл, ёгтлол, бэлгэдлийн сэтгэлгээ бүтээлд тусгалаа олсон байдаг.

Зургийн дүрийг дүгнэхэд, зарим дүр нь хэт хурцадмал шинжтэй амьдралын үнэн бодит байдлыг нээн харуулж байна. Энэ нь бодит байдлыг уран сайхнаар боловсруулж, мэдрэмжийг амьд барилдлагатай нэгдмэл болгосон урлагийн бүтээлийн үр дүн юм. Б.Шаравын нь "Байдал, үйлдэл" хоёроос уран сайхны гол санааг гараж, хүн-амьдрал ба нийгмийн өмнө хариуцсан эрхэм үүргийг хурц тод дүрслэн харуулах зорилго агуулсан үедээ "Нийгмийн дэвшилт" үзэл бодолтой уран бүтээл болжээ гэж үзэх үндэслэл байна.

Энэ бүтээлд бэлгэдэх, адилтган зүйрлэх, ёгтлон илэрхийлэх уран дүрслэлийн аргыг голчлон анхаарч хөгжүүлсний үрээр нийгмийн амьдралын сэдэвт туурвил болж чаджээ. Доктор С.Бадрал: "Марзан Шаравын бүтээлийн нууц нь ил задгай дүрслэгдсэн байгаль хүмүүний амьдралын цаана нүүдэлчин монголчуудын орчлонгийн жам ёсыг дагаж, зохицож ирсэн бичигдээгүй ном, сүсэг бишрэл, эрдэм ухаан байдаг" (Бадрал, 2000, х.6) гэж тэмдэглэсэн бол "И.И.Ломакина "Нэг өдрийн явдал" зураг нь зураачийн ер бусын ертөнцийг үзэх гүн сэтгэлгээний баримтлал юм" гэж дүгнэсэн байдаг (Ломакина, 1970, 20). Тиймээс ч зураачийн зурсан энэ цуврал бүтээлийг монголын төв нутгийн зан үйлийн соёлыг зураглан үзүүлсэн зурагт нэвтэрхий толь гэж дүгнэж болно.

Харин эрдэмтэн Л.Сономцэрэн: "феодалын ангиас гарсан зарим тэргүүний зураач нийгмийн бүдүүлэг байдлыг тэвчиж чадахгүй шүүмжилж, дундад эртний сургаал номлолыг түүхийн шинэ нөхцөлд тохируулах, феодалын бурангуй ёсыг засаж сайжруулах гэж хүсэж байсны илрэл гэж үзнэ" гэж дүгнэжээ (Сономцэрэн, 1976, х.30). Тэр үеийн бурханч зураачид энэ мэт "улс төржсөн" үзэл санааг бүтээлдээ шингээхийг төдийлөн зорилго болгоогүй юм. Өрнөдийн романтизм, оросын нүүдлийн зураачид, хувьсгалч реалистуудын

бүтээл нь нийгмийн хоцрогдож сүйрч байгаа байдлыг ил тод үзүүлж, ард түмнийг тэмцэлд шууд уриалан дуудсан агуулгатай байдаг бол монгол зураачдын бүтээлд энэ агуулга, зорилго харагдахгүй байна.

Монголын ард түмний эрхэмлэлд “Их монгол улсын төр ёсны сэтгэлгээний нэгэн гол шинж нь төрийг шүтэх, тэнгэрлэг язгууртай хааныг дээдлэн хүндэтгэх сэтгэлгээ” уламжлагдан ирсэн түүхтэй (Мягмарсүрэн, 2011, х.111). Дээрх зурагт амьдралд үзэгддэг элдвийн явдлыг үзүүлэхдээ нийгмийг өөрчлөн шинэчлэх санааг тусгаж, харин “Ангийн тэмцэл”-д уриалан дуудсан зорилго агуулаагүй болох нь илэрхий харагдаж байна. Эрдэмтдийн онцолсноор “Монголын нүүдэлчний уран сайхны соёл бол бэлгэ тэмдгийн онцгой тогтолцоот урлаг юм. Энэ урлаг бэлгэ тэмдгийн дүр бүтээх арга нь мөнх ба мөнх бусын диалектикийг илэрхийлсэн мэдээлэл дамжуулах онцгой загвар буй... тойргийн сэтгэлгээний загвар мөн” болох нь зураг урлалд тусгалаа олж байгааг энэ сэдэвт бүтээлийн зохиомжийн шийдэлт харуулдаг (Сарантуяа, 2009, х.119). Монголчуудын урлаг, соёл нь "Сайн заяа, сайн үйл, буян хишгийг урин дуудсан бэлгэдлийн онцгой соёл нь бэлгэ тэмдгийн соёлын нэгэн жишээ буюу өвөрмөц нэгэн загвар" болохыг онцолжээ (Сарантуяа, 2009, 120). Урлагт илэрхийлдэг энэ загвар нь “Өрнөдийн реалист сэтгэлгээнээс ихээхэн ялгаатай бөгөөд харилцан хамаарал, хослол зохицол нь тойрог загвартай ертөнцийн бодтой зүй тогтол” /Мөн тэнд. 121/ гэсэн дүгнэлт дээрх аж байдлын зургийн зохиомжийн шийдэлтэй зохицож байна.

Харин эдгээр зурагт нийгмийн доторх анги давхаргын амьдралын эрс тэс ялгаатай байдлыг хослуулахдаа эгэл ардын амьдралаас эхлээд хүрээ, засаг жасын чуулганы албан ёсны найр, төрийн наадам дээрх шашны зан үйлийн ёслол, наадмын баярын ёслолыг өнгө тодруулан үзүүлж бас төрснөөс үхэх хүртэлх цаг хугацаанд үздэг эрээн бараан амьдралыг тоочин үзүүлж байгалийн жам ёс, хүний нийгмийн амьдралыг бүтээлийнхээ боломжийн агуулгын төв болгон авсан байна. Эрээн бараан амьдралыг үзүүлдэг “хүүрнэлт адилтгал” нь монгол яруу найраг, дууны урлагт “толгой холбох, өлмий холбох, хос холбоц, жигд холбогчийн арга барил” зонхилох бөгөөд энэ арга нь ардын зураг дүрслэлд мөн тусгалаа олжээ. Монгол шүлэг, дууны үгийн агуулгад хүний нийгмийн сайн муу ээлжлэн өнгөрөх цагийн хүрд мэт солигдох учиртай” гэсэн санаа өргөн тусгагдсан байдаг. Харин ч аж байдлын зурагт шашин, төр, иргэд хамтдаа жаргая гэсэн агуулга

хадгалагдаж байгаа нь мөн ажиглагдаж байна.

Эдгээр зургийн зохиомж, өнгө дүрслэлийн онцлогийг авч үзвэл: аж амьдралыг өргөн дэлгэр тусгасан зурагт нь хаан, ноёд түшмэд, харц ард иргэдийн амьдралыг тэдний хооронд болж байгаа үйл явдлаар болж байгаль орчны байдал нь зургийн зохиомжийн ерөнхий дэвсгэр болжээ.

Өнгө захирлын шийдэлт мөн агуулгын тодотгол болж байна. Монголын нэг өдрийг харуулсан цуврал бүтээлд харьцангуй тод өнгөөр зохиомжийн төвд болж: явдлыг тодотгож, хөнгөн зөөлөн өнгийн уусгалтаар эргэн тойронд болж буй үйл өрнөлийг зурсан нь ажиглагддаг. Өнгийн хөгүүд нь ханасан тогтуун байгалийн өнгийн зохицолд нийцэн зохицож монгол ахуйг улам ч тодотгож байна.

Ингэж улс, ард түмний амьдралд буддын шашны нөлөө хүчтэй зонхилж байсан тэр цаг үед аж амьдралын сэдэвт зураг хөгжлийнхөө эхлэлийг тавьж монгол зургийн хөгжлийн шинэ үе эхэлжээ.

ДҮГНЭЛТ

Монголын нийгмийн байдал нь урлагаас шинэ агуулга, илэрхийллийг шаардах болсон нь түүхэн жам ёсны дагуу аяндаа гарч ирсэн үзэгдэл юм. Монгол орны нийгмийн амьдралыг харуулсан зургийг VIII Богд хаан өөрөө үүрэгдэн захиалж, төсөвлөн хөрөнгөжүүлж тэтгэснээр “Аж байдлын сэдэвт зураг” хөгжих үндсийг тавьжээ.

Бурханч зураач нарын дунд жирийн амьдралын байдлыг олон талаас нь зурж үзүүлэх эрмэлзэл бий болсон нь аргагүй монгол орны тусгаар тогтнолын төлөө гэсэн сэтгэлгээ нийгмийн анги давхаргад түгээмэл өрнөж байсны нэг илрэл юм.

Аж байдлын сэдэвт зургийн бүтээл салбарлан хөгжихийн өмнө ард олны гэрт бүтээгдсэн үйчүүр, хөзрийн зурагт мөн анги давхаргын хоорондох харьцааг үзүүлсэн байдаг ч энэ хөзөр үйчүүрийн зурагт тоглоом нь ахуйн хэрэглээний шинжтэй байсан тул нийгмийн сэтгэлгээнд нөлөөлөх түвшинд хүрээгүй юм.

Аж байдлын сэдэвт зургийн бүтээл нь: “Байгаль, мал, амьтны зураг” болон “Дан хүрээ хийдийг зураг”-аас Богд хааны ордны амьдралыг харуулсан “Хүрээ, хийдийг хүний амьдралтай хослуулан үзүүлсэн зураг”-ийн хүрээнд боловсорч, улмаар “Шашин, төрийн баяр ёслолын сэдэвт зураг”-аас нийгэм, ард түмний амьдралыг бүхэлд нь харуулсан “Аж байдлын сэдэвт зураг”-ийн төрөл боловсорч хөгжсөн байна.

Сэдэвт зурагт нь бодит байдлыг дэгсдүүлэн

хэтрүүлэх, санаанаасаа ургуулан зүйрлэж, амьдралын өөрийнх нь хэлбэрийг өөрчлөх тохиолдлыг чадмаг тусгаснаараа хэт бодит бус харин сэтгэлгээний хийсвэрлэх аргад боловсорсон өвөрмөц “Уран зураг” болж чадсан байна. Сэдэвт зурагт зураачийн өөрийн үзэл баримтлал тодоор туссан төдийгүй зарим талаараа нийгмийн үзэл санааны илэрхийлэл болж байжээ.

Гэхдээ анги давхаргын ялгаа, нийгмийн хоцрогдлыг шүүмжилж, ард түмнийг нийгмийг өөрчлөн шинэчлэх тэмцэлд уриалан дуудсан улс төрийн зорилгыг агуулаагүй байна.

Ингэж Богд хаант монгол улсын үед нийгмийн аль ч давхаргад үйлчилсэн жинхэнэ малчин ард түмний сэтгэлд нийцсэн “Аж байдлын сэдэвт зураг” үүсэж монгол зургийн хөгжлийг шинэ шатанд гаргажээ.

дүрслэх урлаг. Улаанбаатар

Хайсиг, Д. (1998). Монгол шашин суртахуун. Хөх хот

Цүлтэм, Н. (1988). Монгол уран зургийн хөгжиж ирсэн тойм. Улаанбаатар

Цүлтэм, Н. (1986). Искусство Монголии с древнейших времен до начала XX века. Москва

Чоймаа, Ш. Нүгэл, буяан, үйлийн үрийн тухай хүүхэд залууст ухуулж ирсэн монгол уламжлал. Будад судлал-№1.-МУИС. Улаанбаатар

Эрдэнэцог, Ц. (2007). Цветовая система в монгольском изобразительном искусстве. ШУ-ны докторын зэрэг горилсон бүтээл. Москва

Лавай. 2012. №8

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Бадрал, С. (2000). Их зураач Б.Шаравын сэтгэлгээний онцлог. Улаанбаатар

Баяртөр, Б. (2009). Монгол зургийн уламжлал, шинэчлэлийн асуудалд. Дүрслэх урлаг одоо цаг, бүтээлч ертөнц. Э.Ш-ний бага хурлын эмхтгэл, х-12-23. Улаанбаатар

Баяртөр, Б. (2008). Монгол уран зураг. Улаанбаатар

Батчулуун, Л. (2009). Марзан Шаравын туурвил зүй. Улаанбаатар

Батчулуун, С. (2011). Монгол зураг дахь орон зайг илэрхийлэх арга ухаан. Эрдмийн ертөнц, №2, х-169-174. Улаанбаатар

Нацагдорж, Ш. (Ред) (1968). Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх-Дэд боть, 1604-1917. Улаанбаатар

Дамдинсүрэн, Д. (2003). Дурсагдахын буянтай бурханч зураач.-Эмхтгэсэн Г.Даариймаа. Улаанбаатар

Ломакина, И.И. (1970). Изобразительное искусство социалистической монголии. Улаанбаатар

Ломакина, И.И. (1974). Марзан Шарав. Москва

Мягмарсүрэн, С. (2011). Монгол төр ёсны түүхийн зарим асуудал. Эрдмийн ертөнц, х-111-116. Улаанбаатар

Сарантуяа, Н. (2000). Бэлэгдлийн соёл ба уран сайхны соёл дахь амьдралыг нөхөн сэргээх үүрэг зориулалт. Эрдмийн ертөнц, х.118-122, Улаанбаатар

Сономцэрэн, Л., Батчулуун, Л. (1989). Монголын дүрслэх урлагийн товч түүх. Улаанбаатар

Сономцэрэн, Л. (1976). Монголын орчин үеийн